

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2008.03.17

Дугаар 132

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Цагдаагийн академийн элсэлтийн журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга /цагдаагийн хурандаа М.Энх-Амгалан/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Д.САНДАГ-ОЧИР

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь Цагдаагийн академид сонсогч, оюутан элсүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Журам нь “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Цагдаагийн байгууллагын тухай хууль”, “Дотоодын цэргийн тухай хууль”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 422 дугаар тушаалаар батлагдсан “Их, дээд сургуульд оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2002 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Боловсон хүчний тухай заавар”, Монгол улсын Шадар сайдын 2008 оны 37 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад алба хаах журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2003 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан “ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын боловсон хүчний ажлын заавар” болон холбогдох бусад эрхийн актад нийцсэн байна.

1.3 Цагдаагийн академийн тусгай зөвшөөрөлд болон энэ журамд заасан мэргэжлийн чиглэлээр элсүүлэх сонсогч, оюутны хяналтын тооны саналыг цагдаагийн төв байгууллага мэргэжлийн холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

Хоёр. Элсэлт зохион байгуулах

2.1 Цагдаагийн академийн элсэлтийг /цаашид “Элсэлт” гэх/ шалгалтын комисс зохион байгуулна.

2.2 Элсэлтийн шалгалтын комисс нь төв ба салбар комиссоос бүрдэнэ.

2.3 Төв комиссыг Цагдаагийн ерөнхий газрын даргын, салбар комиссыг орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн даргын тушаалаар тус тус байгуулна.

2.4 Элсэлтийн шалгалтын төв, салбар комисс нь цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын эрх бүхий алба хаагчдын төлөөллөөс бүрдэнэ.

2.5 Элсэлтийн төв ба салбар комисс үйл ажиллагаандаа тэгш байдал, шударга ёс, хууль дээдлэх, элсэгчдэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх зарчмыг баримтлан элсэлтийн шалгалтад өрсөлдөгчдийн төлөөллөөс хяналт тавих боломжоор хангана.

2.6 Элсэлтийн төв комиссын дарга нь Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, салбар комиссын дарга нь тухайн орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн дэд дарга байна.

2.7 Салбар комисс элсэгчдийн анхан шатны бүртгэл, судалгааг “Боловсон хүчний заавар”-т заасны дагуу хийж бичиг, баримтын бүрдлийг хангах, хянан шалгах, хяналтын тоонд багтсан элсэгчдийг болон элсэлттэй холбогдсон бичиг баримтыг тогтоосон хугацаанд элсэлтийн төв комисст ирүүлэх үүрэг хүлээнэ.

2.8 Төв комисс нийслэлд элсэгчдийн нэмэлт шалгалтыг зохион байгуулах, дүнг гаргах, танилцуулах, элсэлттэй холбогдсон асуудлаар иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлэнэ.

2.9 Элсэлтийн төв, салбар комисс Цагдаагийн академийн элсэлтийн журам, элсүүлэх сонсогч, оюутны хяналтын тоо, элсэлттэй холбогдох шаардлагатай бусад мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.

2.10 Элсэхийг хүссэн иргэний эрүүл мэндийн үзлэгийг нийслэлд Төрийн тусгай албан хаагчдын, орон нутагт аймгийн нэгдсэн эмнэлэг хийж, тэнцэх эсэх дүгнэлт гаргана.

2.11 Шаардлагатай гэж үзвэл элсэлтийн төв комиссын даргын шийдвэрээр элсэгчдийн эрүүл мэндийн баталгаажуулах үзлэгийг дахин хийж болно.

2.12 Эрх зүй мэргэжлийн ангид оюутан элсүүлэх асуудлыг их, дээд сургуулийн концерциумын элсэлтийн комисс зохион байгуулна.

2.13 Эрх зүй-цагдаагийн ажил, эрх зүй-шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын ажил, эрх зүй-гал түймэртэй тэмцэх байгууллагын ажил мэргэжлийн ангид элсэхийг хүссэн иргэн харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэс, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон онцгой байдлын байгууллагад хандан 3 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны хугацаанд өргөдлөө гарган бүртгүүлнэ.

2.14 Энэ журмын 2.13 дахь хэсэгт заасан байгууллагын эрх бүхий алба хаагч 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 25 хүртэл хугацаанд өргөдөл гаргасан иргэнийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2002 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Боловсон хүчний заавар”, Монгол улсын Шадар сайдын 2008 оны 37 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад алба хаах журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2003 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын боловсон хүчний ажлын заавар” болон бусад холбогдох эрхийн актад заасан журмын дагуу судална.

2.15 Эрх зүй-цагдаагийн ажил, эрх зүй-дотоодын цэргийн ажил мэргэжлийн өдөр, эчнээ хэлбэрийн сургалтад элсэхийг хүсэгчдийн бүртгэл, холбогдох бичиг баримтыг Нийслэлд Нийслэлийн цагдаагийн газар, Дотоодын цэргийн штаб, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн газар хэлтэс, эрх зүй-шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын ажил, эрх зүй-гал түймэртэй тэмцэх байгууллагын ажил мэргэжлээр элсэхийг хүсэгчдийн бүртгэл, бичиг баримтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар 07 дугаар сарын 01-ний дотор шалгалтын төв комисст бүртгэлээр хүлээлгэн өгнө.

2.16 Нийслэлийн цагдаагийн газарт харьяалагдахаас бусад цагдаагийн газар, хэлтсээс өдөр, эчнээ хэлбэрийн сургалтад элсэн суралцахыг хүсэгчдийн бүртгэл, холбогдох бичиг баримтыг Цагдаагийн ерөнхий газрын сургалтын асуудал хариуцсан нэгж бүртгэлээр хүлээн авна.

2.17 Элсэгчдийн бүртгэлийг цагдаагийн байгууллагын цахим хуудсан дахь /www.police.gov.mn/ хаягаар бүртгэж болно.

2.18 Цагдаагийн төв байгууллагын сургалтын ажил хариуцсан нэгж энэ зүйлийн 2.17 дахь хэсэгт заасан бүртгэлийг тухай бүр хянаж нэгдсэн бүртгэл хөтлөн харьяаллын дагуу мэдээллийг хүргүүлж, судалгаа хийлгэж болно.

Гурав. Элсүүлэх мэргэжлийн чиглэл, элсэгчдэд тавих шаардлага, авах шалгалт

3.1 Цагдаагийн академид дараах мэргэжлийн чиглэлээр элсүүлэх ба элсэгчдэд дор дурьдсан шаардлага тавина.

№	Элсүүлэх мэргэжлийн чиглэл	Суралцах хугацаа, олгох боловсролын зэрэг	Элсэгчдэд тавигдах шаардлага	Элсэгчдийн бүрдүүлэх материал	Элсэлтийн босго оноо буюу Ерөнхий мэдлэгийн шалгалтаас авсан байвал зохих доод оноо			Сургалтын төлбөр
					Суурь шалгалт	Хавсралт	Нэмэлт шалгалт	
1.	Эрх зүй-цагдаагийн ажил /өдөр/	4 жил Бакалавр	-Цагдаа, Дотоодын цэрэг, Шүүхийн шинжилгээний байгууллагад 2-оос доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, 25 хүртэлх насны, бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой, эрэгтэй албан хаагч; -Тухайн жилд Ерөнхий боловсролын сургуулийг А, В үнэлгээтэй төгссөн, Цагдаагийн академид элсэн суралцах онцлогтой холбогдсон шаардлага, шалгуур үзүүлэлтүүд (ял шийтгэлгүй, ял шийтгэгдэж байгаагүй, биеийн өндөр 170 см-ээс дээш, жин 65 кг-аас багагүй, нүүрний хэлбэр төрх болон бие эрхтний илэрхий өөрчлөлт, гэмтэл согоггүй)-ийг хангасан, 17 нас хүрсэн иргэн	а.Өргөдөл б.Анкет в.Иргэний үнэмлэх, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар г.Гурван үеийн намтар д.Ерөнхий шалгалтын батламж /эх хувиар/ е.Тодорхойлолт/алба хаагчдын хувьд суралцахыг дэмжсэн тухайн алба, газар, хэлтсийн даргын зөвлөлийн хурлын шийдвэр, ажил, зан байдлын тодорхойлолт/ ё.Ял шийтгэгдсэн эсэхийг шалгуулсан хуудас ж.3х4 хэмжээний зураг 3%	11-р анги төгсөгч Нийгмийн тухай мэдлэг 70% /560, түүнээс дээш оноо авсан байх/ Алба хаагч 60% буюу 480, түүнээс дээш оноо авсан байх.	11-р анги төгсөгч Математик 60% /480, түүнээс дээш оноо авсан байх/ Алба хаагч 50% буюу 400, түүнээс дээш оноо авсан байх.	Сургалт төлбөргүй.	
2.	Эрх зүй-криминалистикийн шинжилгээ /өдөр/	4 жил Бакалавр	-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2-оос дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, 25 хүртэлх насны, бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой, эрэгтэй алба хаагч; -Тухайн жилд Ерөнхий боловсролын сургуулийг А, В үнэлгээтэй төгссөн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэр дээр Цагдаагийн академид элсэн суралцах шалгуур үзүүлэлтийг хангасан, 17 нас хүрсэн иргэн	а.Өргөдөл б.Анкет в.Иргэний үнэмлэх, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар г.Гурван үеийн намтар д.Ерөнхий шалгалтын батламж /эх хувиар/ е.Тодорхойлолт /алба хаагчдын хувьд суралцахыг дэмжсэн тухайн алба, газар, хэлтсийн даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Ажил, зан байдлын тодорхойлолт/ ё.Ял шийтгэгдсэн эсэхийг шалгуулсан хуудас ж.3х4 хэмжээний зураг 3%	Математик-70% /560 түүнээс дээш оноо авсан байх/ Алба хаагч	Нийгмийн тухай мэдлэг-60% /480, түүнээс дээш оноо авсан байх/ Алба хаагч	Сургалт төлбөргүй.	
3.	Эрх зүй-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын ажил /өдөр/	4 жил Бакалавр	-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2-оос дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, 25 хүртэлх насны, бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой, эрэгтэй алба хаагч; -Тухайн жилд Ерөнхий боловсролын сургуулийг А, В үнэлгээтэй төгссөн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэр дээр Цагдаагийн академид элсэн суралцах шалгуур үзүүлэлтийг хангасан, 17 нас хүрсэн иргэн	а.Өргөдөл б.Анкет в.Иргэний үнэмлэх, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар г.Гурван үеийн намтар д.Ерөнхий шалгалтын батламж /эх хувиар/ е.Тодорхойлолт /алба хаагчдын хувьд суралцахыг дэмжсэн тухайн алба, газар, хэлтсийн даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Ажил, зан байдлын тодорхойлолт/ ё.Ял шийтгэгдсэн эсэхийг шалгуулсан хуудас ж.3х4 хэмжээний зураг 3%	11-р анги төгсөгч Нийгмийн тухай мэдлэг 70% /560, түүнээс дээш оноо авсан байх/ Алба хаагч 60% буюу 480, түүнээс дээш оноо авсан байх.	Гадаад хэл /орос, англи хэлний аль нэг нь-50% /480, түүнээс дээш оноо авсан байх/	Бие бялдрын шалгалт /Алба хаагчдаас энэ шалгалт авахгүй/	
4.	Эрх зүй – гал түймэртэй тэмцэх байгууллагын ажил /өдөр/	4 жил бакалавр	-Онцгой байдлын байгууллагад 2-оос дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, 25 хүртэлх насны, бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой эрэгтэй алба хаагч; -Тухайн жилд Ерөнхий боловсролын сургуулийг А, В үнэлгээтэй төгссөн, Онцгой байдлын байгууллагын нэр дээр Цагдаагийн академид элсэн суралцах шалгуур үзүүлэлтийг хангасан, 17 нас хүрсэн иргэн	а.Өргөдөл б.Анкет в.Иргэний үнэмлэх, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар г.Гурван үеийн намтар д.Ерөнхий шалгалтын батламж /эх хувиар/ е.Тодорхойлолт /алба хаагчдын хувьд суралцахыг дэмжсэн тухайн алба, газар, хэлтсийн даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Ажил, зан байдлын тодорхойлолт/ ё.Ял шийтгэгдсэн эсэхийг шалгуулсан хуудас ж.3х4 хэмжээний зураг 3%	Математик-60% /480, түүнээс дээш оноо авсан байх/	Гадаад хэл /орос, англи хэлний аль нэг нь-50% /400, түүнээс дээш оноо авсан байх/	Сургалт төлбөргүй.	

5.	Эрх зүй-дотоодын цэргийн ажил /өдөр/	4 жил бакалавр	-Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагад 2-оос доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, 25 хүртэлх насны, бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой, эрэгтэй албан хаагч; -Тухайн жилд Ерөнхий боловсролын сургуулийг А, В үнэлгээтэй төгссөн, Цагдаагийн академид элсэн суралцах онцлогтой холбогдсон шаардлага, шалгуур үзүүлэлтүүд (ял шийтгэлгүй, ял шийтгэгдэж байгаагүй, биеийн өндөр 170 см-ээс дээш, жин 65 кг-аас багагүй, нүүрний хэлбэр төрх болон бие эрхтний илэрхий өөрчлөлт, гэмтэл согоггүй)-ийг хангасан, 17 нас хүрсэн иргэн	а.Өргөдөл б.Анкет в.Иргэний үнэмлэх, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар г. Гурван үеийн намтар д.Ерөнхий шалгалтын батламж /эх хувиар/ е.Тодорхойлолт /алба хаагчдын хувьд суралцахыг дэмжсэн тухайн алба, газар, хэлтсийн даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Ажил, зан байдлын тодорхойлолт/ ё.Ял шийтгэгдсэн эсэхийг шалгуулсан хуудас ж.3x4 хэмжээний зураг 3%	Нийгмийн тухай мэдлэг -60% /480 оноо авсан байх/	Гадаад хэл /орос, англи хэлний аль нэг нь-50% /400, түүнээс дээш оноо авсан байх/	Бие бялдрын нэмэлт шалгалт авна.	Сургалт төлбөргүй.
6.	Эрх зүй /энгийн/	4 жил Бакалавр	-Бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой, 35 хүртэл насны, ял шийтгэлгүй иргэн	а. Өргөдөл б.Анкет в.Иргэний үнэмлэх, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар г. Гурван үеийн намтар д.Ерөнхий шалгалтын батламж /эх хувиар/ е.Ажил, зан байдлын тодорхойлолт ё.Ял шийтгэгдсэн эсэхийг шалгуулсан хуудас ж. 3x4 хэмжээний зураг 3%	Нийгмийн тухай мэдлэг-70% /560 түүнээс дээш оноо авсан байх/	Гадаад хэл /орос, англи хэлний аль нэг нь-50% /400, түүнээс дээш оноо авсан байх/	үгүй	Сургалт төлбөргүй
7.	Эрх зүй-цагдаагийн ажил /эчнээ/	3 жил Бакалавр	-Цагдаа, дотоодын цэрэг, Шүүхийн шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, эрх зүйн бус дээд боловсролтой офицер, улирагч;	а.Өргөдөл б.Анкет в.Иргэний үнэмлэх, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар	Эрх зүй, нийгмийн тухай мэдлэгийн шалгалтыг элсэлтийн төв комисс зохион байгуулна.	үгүй	үгүй	Сургалт төлбөргүй
8.	Эрх зүй-цагдаагийн ажил /эчнээ/	5 жил бакалавр	-Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, бүрэн дунд болон дипломын боловсролын зэрэгтэй, 30 хүртэл насны эрэгтэй, 25 хүртэл настай эмэгтэй офицер, улирагч;	г.Гурван үеийн намтар д.Ерөнхий шалгалтын батламж /эх хувиар/ е.Суралцахыг дэмжсэн тухайн алба, газар, хэлтсийн даргын зөвлөлийн хурлын шийдвэр	Нийгмийн тухай мэдлэг-60% /480, түүнээс дээш оноо авсан байх/	Гадаад хэл /орос, англи хэлний аль нэг нь-50% /400, түүнээс дээш оноо авсан байх/	үгүй	
9.	Эрх зүй-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажил/эчнээ/	5 жил бакалавр	-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 3- аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, бүрэн дунд болон дипломын боловсролын зэрэгтэй, 30 хүртэл насны эрэгтэй, 25 хүртэл настай эмэгтэй офицер, улирагч;	ё. Ажил, зан байдлын тодорхойлолт ж.3x4 хэмжээний зураг 3% з.Эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт и.Ял шийтгэгдсэн эсэхийг шалгуулсан хуудас	Нийгмийн тухай мэдлэг-60% /480, түүнээс дээш оноо авсан байх/	Гадаад хэл /орос, англи хэлний аль нэг нь-50% /400, түүнээс дээш оноо авсан байх/	үгүй	

3.2 Элсэхийг хүссэн иргэдээс авах бие бялдрын нэмэлт шалгалтыг дараах үзүүлэлтээр дүгнэнэ. Үүнд:

№	100 метрийн гүйлт /секунд/		3000 метрийн гүйлт /минут/		500 метрийн гүйлт /минут/		Гар дээр суних /удаа/		Гэдэс таталт /30 секундэд хийх удаа/	16 кг-ын туухай /удаа/	Сандал дээгүүр харайх /30 секундэд хийх удаа/	Дүүжин савлуурт /удаа/
	Эр	эм	эр	эм	эр	эм	эм	эр	эм	эр		
1	17.25	19.25	17.1	6.1	1	-	-	1	3			
2	17.20	19.20	17.0	6.0	2	1	7	2	4	1		
3	17.15	19.15	16.5	5.5	3	-	8	3	5			
4	17.10	19.10	16.4	5.4	4	2	9	4	6	2		
5	17.05	19.05	16.3	5.3	5	-	10	5	7			
6	17.00	19.00	16.2	5.2	7	3	11	7	8	3		
7	16.55	18.55	16.1	5.1	9	-	12	9	9			
8	16.50	18.50	16.0	5.0	14	4	13	11	10	4		
9	16.45	18.45	15.5	4.5	17	5	14	13	11			
10	16.40	18.40	15.4	4.4	20	6	15	15	12	5		
11	16.35	18.35	15.3	4.3	23	7	16	17	13			
12	16.30	18.30	15.2	4.2	26	8	17	19	14	6		
13	16.25	18.25	15.1	4.1	29	9	18	21	15			
14	16.20	18.20	15.0	4.0	32	10	19	23	16	7		
15	16.15	18.15	14.5	3.5	35	11	20	25	17			
16	16.10	18.10	14.4	3.4	38	12	21	27	18	8		
17	16.05	18.05	14.3	3.3	41	13	22	29	19	9		
18	16.00	18.00	14.2	3.2	44	14	23	31	20	10		
19	15.55	17.55	14.1	3.1	47	15	24	33	21	11		
20	15.50	17.50	14.0	3.0	50	16	25	35	22	12		

Дөрөв: Хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэх

4.1 Албан үүрэг гүйцэтгэх явцдаа онцгой гавьяа байгуулсан, төв байгууллагын ажил мэргэжлийн болон хөдөлмөрийн аваргаар 2 буюу түүнээс дээш удаа шалгарсан, спортын өндөр амжилт гаргасан цагдаагийн байгууллагын 3 хүртэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын тус бүр 1 албан хаагчийг Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр ажилласан жил харгалзахгүйгээр урилгаар элсүүлэн суралцуулж болно.

4.2 Урилгаар суралцах элсэгчийн ерөнхий мэдлэгийн шалгалтын доод оноо нь авбал зохих нийт онооны 50 хувиас багагүй байвал зохино.

Тав. Шалгаруулалт явуулах

5.1 Элсэхийг хүссэн иргэн, алба хаагчийн ерөнхий мэдлэгийн болон нэмэлт шалгалтын онооны нийлбэрээр хяналтын тоог үндэслэн жагсаалт гаргаж, энэ тухай элсэхийг хүсэгчдэд мэдээлнэ.

5.2 Элсэлтийн шалгалтын оноо тэнцсэн тохиолдолд боловсролын үнэмлэх, дипломын голч дүн, ажлын үр дүн, авьяас, чадвар зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан шалгаруулалтыг төв комисс хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.3 Ерөнхий мэдлэгийн шалгалтын оноо нь энэ журамд заасан шаардлагыг хангасан боловч тогтоосон хугацаанд элсэлтийн нэмэлт шалгалтад ороогүй, хоцорсон, хангалтгүй үнэлгээ авсан, мөн эрүүл мэндийн үзлэгээр Академид суралцах шаардлагыг хангаагүй иргэн, алба хаагчийг шалгалтад тэнцээгүйд тооцно.

5.4 Хяналтын тоонд багтсан элсэгч суралцахаас татгалзсан, тодорхой шалтгаанаар хасагдсан бол онооны дарааллаар дараагийн иргэн, алба хаагчийг элсүүлэх асуудлыг төв комисс хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.5 Бие бялдрын нэмэлт шалгалт өгөх хувийн бэлтгэлийг хангаагүй, иргэний үнэмлэхгүй зэрэг элсэлтийн журам зөрчсөн иргэн, албан хаагчийг шалгалтаас гаргаж, энэ тухай тэмдэглэл үйлдэн, нийтэд мэдээлнэ.

5.6 Элсэлтийн шалгалтыг дахин болон нөхөн авахгүй.

Зургаа. Шийдвэр гаргах

6.1 Элсэлтийн төв комисс шалгалтын дүнг нэгтгэн Цагдаагийн ерөнхий газрын даргад 07 дугаар сарын 15-ны дотор илтгэн танилцуулна.

6.2 Цагдаагийн ерөнхий газрын дарга элсэлтийн төв комиссын шийдвэрийг үндэслэн элсэгчдийг Цагдаагийн Академид суралцуулах шийдвэр гаргана.

6.3 Энэ журмын 6.2 дахь хэсэгт заасан шийдвэрийг төв комисс элсэгчдэд мэдээлж, суралцах эрхийн бичиг олгоно. Эрхийн бичигт элсэгчдийг бүртгэх газар, хугацааг тодорхой заана.

Долоо. Бусад зүйл

7.1 Академид элсэгчдийн бичиг баримтыг элсэгчдийг суралцуулах тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор төв комиссын нарийн бичгийн дарга Цагдаагийн академид бүртгэлээр хүлээлгэн өгнө.

7.2 Нийслэл болон орон нутгаас тус академийн “эрх зүй” мэргэжлийн ангид элссэн иргэн бүртгүүлэхдээ суралцах эрхийн бичиг, иргэний ба боловсролын бичиг баримтаа эх хувиар, сургалтын төлбөр төлсөн болон төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдах эсвэл Төрийн албаны тухай хуулийн дагуу сургалтын төлбөрийн тодорхой хувийг төр хариуцахтай холбогдсон бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

7.3 Элсэгч хичээлийн жилийн танхимын сургалт, сургалтын төвийн сургалт эхэлснээс хойш ажлын 5 ба түүнээс дээш хугацаагаар сургалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол “Цагдаагийн академийн дотоод журам”-д заасны дагуу академиас хасна.

Найм. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

8.1 Энэхүү журмыг зөрчигчид хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.2 Элсэгчдийн хувийн хэргийн бүрдэл дутуу, элсэгчдийн иргэний болон боловсролын үнэмлэх, диплом, бусад бичиг баримт засвартай, хуурамч болох нь тогтоогдсон тохиолдолд материалыг буцаах ба үүнтэй холбоотой учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР